



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/115

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянгол овогт Намжаагийн Энхбаяр /УГ81112836/ нь Шивээговь сумын 1-р баг, 12 дугаар байрны баруун талд “Автограж”-ийн зориулалттай 21м2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Онолт овогт Санжидын Мөнхжаргал /ЗЛ85032110/-д Шивээговь сумын 1-р баг, 12 дугаар байрны баруун талд байрлах 21м2 газрыг “Автограж”-ийн зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн /С.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн С.Мөнхжаргалтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/47 дугаар захирамжийн 1 дэх бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА